



**НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035  
Утас/Факс: (976-11) 32-71-99,  
<http://www.ulaanbaatar.mn>

2018.06.11 № 03/2403  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

┌ **НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН** ┐  
**ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 138 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/509 дүгээр захирамжийг хүргүүлж байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөнө үү.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжийг хавсаргав.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА  М.ОТГОНБАЯР

D:/2018/тоот/А-5ТГ.Docx

111020002115

С. Баасанхуяг

2018 06 08 / 0707/9



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 5 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар  
хот

Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг  
хангах зарим арга хэмжээний тухай

Тагнуулын байгууллагын тухай хуулийн 11.1.6, Харилцаа холбооны тухай хуулийн 20.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчид ажлын байранд төрийн албаны интернэт сүлжээгээр олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтууд (Facebook, Twitter, Youtube, Instagram, Steam гэх мэт)-ыг ашиглахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авахыг Тагнуулын ерөнхий газрын дарга Д.Гэрэл, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбат нарт даалгасгай.

2. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн дарга нарт үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тагнуулын ерөнхий газрын дарга Д.Гэрэлд үүрэг болгосгай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга  
УХА0064

У.ХҮРЭЛСҮХ

Г.ЗАНДАНШАТАР



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/509

Улаанбаатар хот

Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг  
хангах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчит болон харьяа байгууллагуудын ажилтан, албан хаагчдын ажлын хэрэгцээний интернет сүлжээнээс олон нийтийн сүлжээ, онлайн тоглоом, видео сан бүхий сайтуудад нэвтрэхийг хориглосугай.

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасны дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Нийслэлийн Мэдээллийн технологийн газар /О.Чинзориг/ болон дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД

111020002423